

Регистрийн дугаар 2708701, Улсын бүртгэлийн дугаар 9019015031

**ГАДААДЫН ИРГЭН, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

2014 оны 09 сарын 06

Завхан аймаг Дөрвөлжин сум

Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол улсын Газрын тухай хууль, Завхан аймаг /нийслэл/-ийн Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2012 оны 12 сарын 13-ны өдрийн 98 тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Хоролдорж овогтой Сувд-эрдэнэ, Газар ашиглагчийг төлөөлж Баян Айраг Эксплорэйшн ХХК-ны гүйцэтгэх захирал Виллиам Томас Колвин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараах зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 2856,65 /га/. Үүнээс:

	Нэгж талбарын тодорхой хэсгийн ашиглах зориулалт	Га тутмын төлбөрийн хэмжээ /мян төг/	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ /га/	Газрын төлбөр /мян төг/
1	Уурхайн эдэлбэр газар	160.0	589.8	94368.0
2	Барилга байгууламж	40.0	137.25	5490.0
3	Уурхайн нөөц талбай	2.4	2129.6	5111.04
	Нийт		2856.65	104969.04

Талууд

А. Н. - 24



2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Нэгжийн үнэ: 160000 төгрөг, 40000 төгрөг, 2400 төгрөг

Бүгд үнэ: 104969040 төгрөг

/нэг зуун дөрвөн сая есөн зуун жаран есөн мянга дөчин төгрөг/
/үсгээр/

1-р улирал 26242260 төг

2-р улирал 26242260 төг

3-р улирал 26242260 төг

4-р улирал 26242260 төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор тэнцүү хэмжээгээр Төрийн сан банкны 090500995 тоот дансанд шилжүүлнэ.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гаргасан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчилж тогтоолгоогүй бол зохих зардалыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх үүрэг

3.1. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу газрыг ашиглах.

3.2. Газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах.

3.3. Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгах.

3.4. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх.

3.5. Газрын төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх.

3.6. Газар өмчлөгчөөс газар ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх.

3.7. Газрын кадастрын зураглалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж баталгаажуулах.

3.8. Энэхүү гэрээний 2.1-д заасан зориулалтын дагуу уг газрыг ашиглах.

3.9. Холбогдох хууль тогтоомжоор тогтоогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Х. А-Ч

Талууд



Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

- 4.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах.
- 4.2. Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараах шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй. Үүнд: "Газрын тухай хууль"-ийн 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.2, 51.3 дэх заалтуудыг хэрэгжүүлэх.
- 4.3. "Газрын тухай хууль"-ийн 35.3.1-35.3.5-д заасан үүргээ гүйцэтгээгүй, мөн хуулийн 40.1.1-40.1.6-д заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах.
- 4.4. Газар ашиглуулах гэрээг жил бүрийн 11 дүгээр сарын 1-10-ны дотор дүгнэх.
- 4.5. холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.


Тав. Газрын талаарх эд хөрөнгийн зарим зохицуулалт

- 5.1. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл Монгол улсын Иргэний хууль болон Газрын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 5.2. энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 5.3. Гэрээ байгуулагч талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл
 - Орчны тохижилтын сайжруулах
 - Ашиглаж буй газартаа мод тарьж, ногоон байгууламж байгуулах
 - Ашиглаж буй газартаа шинээр нэмж барилга байгууламж барих бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан байна

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.
- 6.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай байгуулав.
- 6.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол улсын бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Талууд






Гэрээний талуудын харилцах албан ёсны хаяг, харилцах утас

Завхан аймаг, Дөрвөлжин сум
Газар ашиглуулагч: ЗДТГазар
Харилцах утас: 89010633

Газар ашиглагч:	Регистрийн дугаар	2708701
	Улсын бүртгэлийн дугаар	9019015031
	Харилцах дансны дугаар	Хаан банк 5021114327
	Харилцах утас:	77116100


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглуулагчийг төлөөлж:
Завхан аймаг /нийслэл/-ийн
Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн
Газрын асуудал эрхэлсэн
албан тушаалтан
Хоролдорж овогтой Сувд-эрдэнэ



/он, сар, өдөр/

Газар ашиглагчийг төлөөлж:
Улаанбаатар хот /нийслэл/-ийн
Сүхбаатар /дүүрэг/-ийн
Баян айраг Эксплорэйшн ХХК-ны
Гүйцэтгэх захирал
Виллиам Томас Колвин-У



/он, сар, өдөр/

Энэхүү гэрээний 1 хувийг тоот дугаар бүхий нэгж талбарын
хувийн хэрэгт хадгалав.

7.14.04

Талууд

Регистрийн дугаар 2708701, Улсын бүртгэлийн дугаар 9019015031

**ГАДААДЫН ИРГЭН, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ** *L*

2014 оны 10 сарын 02

Завхан аймаг Дөрвөлжин сум

Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол улсын Газрын тухай хууль, Завхан аймаг /нийслэл/-ийн Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2012 оны 09 сарын 24-ны өдрийн 79 тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Хоролдорж овогтой Сувд-эрдэнэ, Газар ашиглагчийг төлөөлж Баян Айраг Эксплорэйшн ХХК-ны гүйцэтгэх захирал Виллиам Томас Колвин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараах зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:


- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 18.5 /га/. Үүнээс:

	Нэгж талбарын тодорхой хэсгийн ашиглах зориулалт	Га тутмын төлбөрийн хэмжээ /мян төг/	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ /га/	Газрын төлбөр /мян төг/
1	Усны хоолой, эрчим хүчний шугам барих	80000	18.5	1480.0
Нийт				1480.0

Талууд



2.2. Бүгд үнэ: 1480000 төгрөг
/нэг сая дөрвөн зуун наян мянган төгрөг/
/үсгээр/

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор тэнцүү хэмжээгээр Төрийн сан банкны 090500995 тоот дансанд шилжүүлнэ.
/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гаргасан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчилж тогтоолгоогүй бол зохих зардалыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх үүрэг

3.1. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу газрыг ашиглах.

3.2. Газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах.

3.3. Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгах.

3.4. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх.

3.5. Газрын төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх.


3.6. Газар өмчлөгчөөс газар ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх.

3.7. Газрын кадастрын зураглалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж баталгаажуулах.

3.8. Энэхүү гэрээний 2.1-д заасан зориулалтын дагуу уг газрыг ашиглах.

3.9. Холбогдох хууль тогтоомжоор тогтоогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Талууд



Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

- 4.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах.
- 4.2. Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараах шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй. Үүнд: "Газрын тухай хууль"-ийн 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.2, 51.3 дэх заалтуудыг хэрэгжүүлэх.
- 4.3. "Газрын тухай хууль"-ийн 35.3.1-35.3.5-д заасан үүргээ гүйцэтгээгүй, мөн хуулийн 40.1.1-40.1.6-д заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах.
- 4.4. Газар ашиглуулах гэрээг жил бүрийн 11 дүгээр сарын 1-10-ны дотор дүгнэх.
- 4.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн зарим зохицуулалт

- 5.1. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл Монгол улсын Иргэний хууль болон Газрын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 5.2. Энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 5.3. Гэрээ байгуулагч талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл
 - Орчны тохижилтын сайжруулах
 - Ашиглаж буй газартаа мод тарьж, ногоон байгууламж байгуулах
 - Ашиглаж буй газартаа шинээр нэмж барилга байгууламж барих бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан байна
 - Орчны хог хаягдалыг тухай бүр цэвэрлэх
 - Тухайн газрыг зориулалтын дагуу ашиглан, үйл ажиллагаагаа явуулах

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.
- 6.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай байгуулав.
- 6.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол улсын бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Талууд




Гэрээний талуудын харилцах албан ёсны хаяг, харилцах утас

Завхан аймаг, Дөрвөлжин сум
Газар ашиглуулагч: ЗДТГазар
Харилцах утас: 89010633

Газар ашиглагч:	Регистрийн дугаар	2708701
	Улсын бүртгэлийн дугаар	9019015031
	Харилцах дансны дугаар	Хаан банк 5021114327
	Харилцах утас:	77116100

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


Газар ашиглуулагчийг төлөөлж:
Завхан аймаг /нийслэл/-ийн
Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн
Газрын асуудал эрхэлсэн
албан тушаалтан
Хоролдорж овогтой Сувд-эрдэнэ



/Газрын үсэг/ /тамга/

/он, сар, өдөр/

Газар ашиглагчийг төлөөлж:
Улаанбаатар хот /нийслэл/-ийн
Сүхбаатар /дүүрэг/-ийн
Баян айраг Эксплорэйшн ХХК-ны
гүйцэтгэх захирал
Виллиам Томас Колвин



/Газрын үсэг/ /тамга/

/он, сар, өдөр/

Энэхүү гэрээний 1 хувийг тоот дугаар бүхий нэгж талбарын
хувийн хэрэгт хадгалав.

Талууд

(Handwritten signature)

**ГАДААДЫН ИРГЭН, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ 3**

2012 оны 07сарын 27 өдөр

Завхан аймаг, Дөрвөлжин сум

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Завхан аймаг /нийслэл/-ийн Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2012 он 07-р сарын 09-ны өдрийн 66 тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Хоролдорж овогтой Сувд-эрдэнэ, Газар ашиглагчийг төлөөлж Баян Айраг Эксплорэйшн ХХК-ны ерөнхий захирал ажилтай Юра овогтой Энхтүвшин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараах зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 40 /га/.

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг
эзэмших зориулалт

Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ

1. Уурхайчдын хотхон, ахуйн барилгын	40	/га/
2.	/га/
3.	/га/
4.	/га/
5.	/га/

2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Нэгжийн үнэ 40000 төгрөг /үсгээр/ /Дечин мянган төгрөг/

Бүгд үнэ 1600000 төгрөг /үсгээр/ /Нэг сая зургаан зуун мянган төгрөг/

Үүнээс:

1-р улиралд.....төг 3-р улиралд 1600000 төг

2-р улиралд.....төг 4-р улиралд төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар ашиглуулагчийн Төрийн сан банкны 090500995 тоот дансанд шилжүүлж байна.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гаргасан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх үүрэг

3.1. Гэрээний нөхцөлийн дагуу газрыг ашиглах

3.2. Газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах

3.3. Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгах

3.4. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх

3.5. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх

3.6. Газар өмчлөгчөөс газрын ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх

3.7. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

4.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах

4.2. Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараах шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй. Үүнд:



“Газрын тухай хууль”-ийн 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.2, 51.3 дэх заалтуудыг хэрэгжүүлэх

4.3. “Газрын тухай хууль”-ийн 35.3.1.-35.3.5-д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах

4.4. Газар ашиглуулах гэрээг жил бүр дүгнэх

4.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл иргэний болон, газрын тухай хуулийн дагуу холбогдох заалтыг үндэслэн шийдвэрлэнэ.

5.2. Энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.3. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл:

.....
.....
.....

Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн /5/ таван жилийн хугацаатай байгуулав.

6.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас

Завхан аймаг, Дөрвөлжин сум

Газар ашиглуулагч: ЗДТГазар

Харилцах утас : 88989289

Регистр /улсын бүртгэл/-ийн дугаар

9	0	1	9	0	1	5	0	3	1
---	---	---	---	---	---	---	---	---	---

Газар ашиглагч:

Харилцах дансны дугаар

Харилцах утас: 77116100

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглуулагчийг төлөөлж:


Завхан аймаг /нийслэл/-ийн

Дөрвөлжин сум /дүүрэг/-ийн

Газрын асуудал эрхэлсэн албан

тушаалтан

Хоролдорж овогтой Сувд-Эрдэнэ


/гарын үсэг/



Газар ашиглагчийг төлөөлж:

Улаанбаатар хот /нийслэл/-ийн

Сүхбаатар /дүүрэг/-ийн

Баян Айраг Эксплорэйшн ХХК-ны

ерөнхий захирал

Юма овогтой Энхтүвшин


/гарын үсэг/



Энэхүү гэрээний нэг хувийг тоот дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

ГХГЗЗГ-ын даргын 157 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

Улсын бүртгэлийн дугаар 9019015031,
Регистрийн дугаар 2708701

**ГАДААДЫН ИРГЭН, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ 4**

2014 оны 08 сарын 28 өдөр

Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, *Завхан* аймаг /нийслэл/-ийн *Эрдэнэхайрхан* сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2014 оны 08-р сарын 28-ны өдрийн /8/ тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж Эрдэнэхайрхан сум /дүүрэг/-ийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Цэнд-Аюуш овогтой Доржбал газар ашиглагчийг төлөөлж, /Баян Айраг Эксплорэйшн ХХК/-нийн гүйцэтгэх захирал ажилтай Виллиам Томас Колвин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараах зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
- 1.3. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 72,86 /га/.

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт	Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ
---	---

1. Усны хоолой, эрчим хүчний шугам барих	72,86	/га/
2.	/га/
3.	/га/
4.	/га/
5.	/га/
2.2. Газрын төлбөрийн хэмжээ		

В. Доржиев

[Signature]

Нэгжийн үнэ 80000 төгрөг /үсгээр/ наян мянга /

Бүгд үнэ 5828800 төгрөг /үсгээр/ таван сая найман зуун хорин найман мянга найман зуу /

Үүнээс

1-р улиралд 1457200 төг

3-р улиралд 1457200 төг

2-р улиралд 1457200 төг

4-р улиралд 1457200 төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийнтоот дансанд шилжүүлж байна.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар ашиглуулагчийн Төрийн сан банкны 092200995 тоот дансанд шилжүүлж байна.

2.5. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гаргасан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.6. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх үүрэг

3.1. гэрээний нөхцлийн дагуу газрыг ашиглах

3.2. газар өмчлөгчөөс газрын төдөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах

3.3. гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгах

3.4. газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх


3.5. төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх

3.6. газар өмчлөгчөөс газрын ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх

3.7. холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

4.1. газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах



4.2. уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараах шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй. Үүнд:

“Газрын тухай хууль” –ийн 50-р зүйл , 51-р зүйлийн 51.2, 51.3 дэх заалтуудыг хэрэгжүүлэх

4.3. “Газрын тухай хууль”-ийн 35.3.1.-35.3.6-д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах

4.4. газар ашиглуулах гэрээг жил бүрийн 11-р сарын 1-10-ны дотор дүгнэх

4.5. холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл Монгол Улсын “Иргэний хууль” болон “Газрын тухай хууль”-ийн дагуу шийдвэрлэнэ.

5.2. энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь “Иргэнийн хууль”-д заасны дагуу шийдвэрлэгдэнэ.

Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.3. гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл:

Орчны тохижилтыг сайжруулж, ашиглах газартаа ногоон байгууламж байгуулан, мод тарьж, хөрсний бохирдлыг арилган, хог хаягдлыг тухай бүр цэвэрлэн, ашиглалтын газартаа шинээр нэмж барилга байгууламж барих бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан байна.

Зургаа. Бусад зүйл

6.1. гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2. энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн Нэг /үсгээр/ жилийн хугацаатай байгуулав.

6.3. энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум

Ашиглуулагч:

ЗДТГазар

Харилцах утас: 88608875

У. Софи

(Signature)

Ашиглагч:

Регистрийн дугаар: 2708701

Улсын бүртгэлийн дугаар: 9019015031

Харилцах дансны дугаар: Хаан банк 5021114327

Харилцах утас: 77116100

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглуулагчийг төлөөлж:

Завхан аймаг /нийслэл/-ын

Эрдэнэхайрхан сум /дүүрэг/-ийн

Газрын асуудал эрхэлсэн албан

тушаалтан Цэнд-Аюуш овогтой Доржбал



/гарын үсэг/

/тамга/

Газар ашиглагчийг төлөөлж:

Улаанбаатар хот /нийслэл/-ийн

Сүхбаатар /дүүрэг/-ийн Баян

Айраг Эксплорэйшн ХХК-ний

гүйцэтгэх захирал Виллиам Томас

Колвин



/гарын үсэг/

/тамга/

Энэхүү гэрээний нэг хувийгтоот дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

**ЗАВХАН АЙМГИЙН ЭРДЭНЭХАЙРХАН СУМААС
БАЯН АЙРАГ ЭКСПЛОРАЙШН ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2014 оны 3 дугаар сарын 23-ны өдөр


Энэхүү хамтын ажиллагааны гэрээ(цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутгийн захиргаа (цаашид “Сум” гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сэнтрал Тауэр, 7 давхарт орших Баян Айраг Эксплорэйшн ХХК (цаашид “Компани” гэх) нар Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийг үндэслэн дор дурдсан нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

- 1.1 Энэхүү Гэрээгээр Компани нь сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн ам, мал аж ахуй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг стандартад заасан хэмжээнд байлгах, орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, компаний үр ашгийг нэмэгдүүлэх болон компаний үйл ажиллагааны эдийн засгийг хүндэтгэж, тогтвортой тасралтгүй хэвийн байдлыг хангаж, орон нутгийн удирдлага, нутгийн иргэд, компаний хооронд ил тод, шударга нээлттэй хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ хууль дээдлэх, тэгш оролцоотой байх, шударга ёсыг сахих, харилцан ашигтай, ил тод нээлттэй байх, шударгаар сахин биелүүлэх зарчмуудыг хүндэтгэн дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрөв.
- 1.3 Баян-Айраг Эксплорэйшн” ХХК нь Ашигт малтмалын тухай хуульд заасан журмын дагуу Завхан аймаг, Дөрвөлжин сумын нутаг дэвсгэрт орших Өвөр Баян айраг нэртэй газар ашигт малтмал ашиглах 13409А тоот тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд уг тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай дээр ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах “Баян айраг” төслийг хэрэгжүүлэхэд Эрдэнэхайрхан сумын нутаг дэвсгэрт орших усны эх үүсвэрээс зохих хэсгийг ашиглах зөвшөөрөл авсан болно.


Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэ Гэрээ нь Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Компанийн 13409А тоот тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн уурхайн үйл ажиллагаа дуусгавар болох хүртэл Гэрээ хүчин төгөлдөр байна.




Гурав. Байгаль орчныг хамгаалах


- 3.1 Сум нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр дараах эрх, үүрэг хүлээнэ:
- 3.1.1 Байгаль орчныг хамгаалах талаар Компаний үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хяналт тавьж зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэх буюу хариуцлага хүлээлгүүлэхээр эрх бүхий байгууллага албан тушаалтанд гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 3.1.2 Энэхүү гэрээний зорилго, мөн чанар, агуулга, ач холбогдлыг орон нутгийн иргэдэд мэдээлэх;
 - 3.1.3 Компаний хууль ёсны үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй явуулах таатай нөхцлийг бүрдүүлэх, хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.4 Ус ашиглахтай холбоотой үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал бий болсон тохиолдолд урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр компаний эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авч усны хяналт шинжилгээ хийх;
 - 3.1.5 Компани холбогдох хууль болон энэ гэрээгээр хүлээсэн байгаль орчны үүрэгтэйгээ холбогдуулан Суманд хүргүүлсэн тайлан мэдээллийг тухай бүр нь хүлээн авч, танилцах, иргэдэд мэдээлэх;
 - 3.1.6 Компанийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгах, нөхөн сэргээлт хийхийг Компаниас шаардах;
 - 3.1.7 Компани холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлээгүй тохиолдолд Компани уг үүргээ биелүүлэх хүртэл хууль тогтоомжид заасан үндэслэлээр тухайн компанид төсөлтэй холбоотой зөвшөөрөл (газар, ус ашиглах гэх мэт) болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал өгөхгүй байх;
 - 3.1.8 Байгаль орны чиглэлээр хууль болон энэхүү гэрээгээр хүлээсэн Компанийн үүргийн биелэлтэд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэг бүхий сумын иргэдийн оролцоотой төрийн бус байгууллага (ТТБ)-ын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
 - 3.1.9 Компанийн төсөл орчмын усны дээжид улирал тутам буюу шаардлагатай тухай бүрд хийлгэх шинжилгээнд хяналт тавих.
- 3.2 Компани нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр дараах эрх, үүрэг хүлээнэ:
- 3.2.1 Ашиг малтмалын тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудад заасан эрх эдэлж, үүрэг хүлээх ба байгаль орчны холбогдолтой Монгол Улсын стандарт, нормыг ханган ажиллах;
 - 3.2.2 Компанийн хэрэгжүүлж буй төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуулбар хувийг сумд хүргүүлж чандлан мөрдөх;
 - 3.2.3 Энэхүү Гэрээний 3.1.9-д заасны дагуу усны дээж авах мэргэжлийн байгууллага, Сумын захиргаанд хууль, Компанийн дотоод журамд заасны дагуу зөвшөөрөл олгох;



- 3.2.4 Шаардлагатай тохиолдолд эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг тодорхойлох, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 3.2.5 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уул уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, мал, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.2.6 Экологийн боловсрол, хүмүүжил олгох чиглэлээр ТББ, сумд дэмжлэг үзүүлэх;
- 3.2.7 Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хяналт, мониторинг хийх, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, төслөөс байгаль орчинд нөлөөлж буй нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл хийх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 3.2.8 Малчдын өвөлжөөний нутгийн ургацыг нэмэгдүүлэх, гүний усны нөөцийг хэвэнд нь хадгалах, усны нөөц багасхаас сэргийлэх зорилгоор Гантай жилүүдэд Байгаль орчны төрийн болон төрийн бус байгууллага болон цаг уур орчны шинжилгээний байгууллагатай хамтран үүлэнд зориудаар нөлөөлж бороо оруулах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 3.2.9 Компани нь сумд дараах мэдээ тайланг хүргүүлнэ:
 - а) сумаас ашиглаж буй усны нөөцөнд сар бүр мониторинг хийж, мэдээг ТББ болон сумд хүргүүлэх;
 - б) Төрийн байгууллага, албан тушаалтанд хуульд заасан тайлан, мэдээг тухай бүрд нь хүргүүлж байх
- 3.2.10 Уурхайн үйл ажиллагаа дуусгавар болоход сумын нутаг дэвсгэр дээрх цооног, тоног төхөөрөмжүүдийг сумын эзэмшил, өмчлөлд шилжүүлж өгөх.

Дөрөв. Ажлын байр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авалт хийх талаар


- 4.1 Сум ажлын байр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авалт хийх талаар дараах эрх, үүрэг хүлээнэ:
 - 4.1.1 Компаниас зарласан ажлын байрыг сумын иргэдэд нээлттэй мэдээлэх;
 - 4.1.2 Компанитай хамтран сумын нутгийн иргэдийг сургалтад хамруулах замаар ажлын байран дээр дэвших боломжийг бүрдүүлэх;
 - 4.1.3 Компанид нийлүүлэх худалдан авалтад тавигдах шаардлагыг хангуулж, төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх;
 - 4.1.4 Компаниас зарласан ажлын байр дахь сонгон шалгаруулалтанд орон нутгаас ажиллах нэр дэвшигчдийн талаар Сумын засаг дарга санал өгөх, хэрэгжилтийн талаар мэдээлэл хүлээн авах.
- 4.2 Компани нь ажлын байр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авалт хийх талаар дараах эрх, үүрэг хүлээнэ:




- 4.2.1 Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэн стандартад заасан ажлын байрны нөхцлийг хангах;
- 4.2.2 Компанид гарсан сул ажлын байрыг нутгийн иргэдэд санал болгож замаар сумын иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлж уурхайд ажиллаж буй Завхан аймгийн орон нутгийн ажилчдын 25 хувьд хүргэх;
- 4.2.3 Сумын харъяалалтай компанийн ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх мэргэжилтэй болгоход анхаарч ажиллах
- 4.2.4 Өөрсдийн санаачилгаар жижиг, дунд үйлдвэр байгуулан ажиллаж байгаа Сумын харъяалалтай иргэд, аж ахуй нэгж, байгууллагууд дунд компани хэрэгцээт бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэх төслийг сонгож шалгаруулах, өөрийн мэдлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх, тэдний үйлдвэрлэсэн стандарт шаарлагыг бүрэн хангасан бараа, ажил үйлчилгээг худалдан авах замаар ажлын байр нэмэгдүүлэх;
- 4.2.5 Суман дахь төлөөлөгчийн газрыг уурхайн үйл ажиллагаа дуустал 2 доошгүй орон тоотойгоор ажиллуулах, хамтын ажиллагааны гэрээний биелэлтэнд хяналт тавих ажлын хэсэгтэй хамтран ажиллах;
- 4.2.6 Сумын хүн амыг төвлөрүүлэх зорилгоор тус сумд шилжин ирсэн мэргэжлийн боловсон хүчнийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх;

Тав. Дэд бүтэц, нийгмийн асуудал

- 5.1 Сум дэд бүтэц, нийгмийн асуудлын талаар дараах эрх, үүрэг хүлээнэ:
 - 5.1.1 Шаардлагатай тохиолдолд уурхайд эмнэлэг, харилцаа холбоо цагдаагийн үйлчилгээ үзүүлэх;
 - 5.1.2 Уул уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай зам, харилцаа холбоо эрчим хүчний байгууламж барихад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;
 - 5.1.3 Хөрсний эвдрэл тоосжилтоос хамгаалах зорилгоор Сумын нутаг дэвсгэр улсын болон орон нутгийн чанартай замгүй газраар хүнд даацын тээвэр хийхийг хориглох,
- 5.2 Компани нь дэд бүтэц, нийгмийн асуудлын талаар дараах эрх, үүрэг хүлээнэ:
 - 5.2.1 Малчдын өвөлжөө, хаваржаа, түүний тойрон дахь малын бэлчээр хадлангийн талбай, худаг, ундны усны эх үүсвэрт хохирол учруулахгүй байх хохирол учирвал хуульд заасны дагуу арга хэмжээ авах;
 - 5.2.2 Ган, зуд, гоц халдварт өвчин зэрэг байгалийн давтагдашгүй хүчин зүйлүүдэд өртсөн тохиолдолд нийгмийн хариуцлагыг хүлээж дэмжлэгийг хөтөлбөр болгон хэрэгжүүлэх;
 - 5.2.3 Сумын нутаг дэвсгэрийн бэлчээрийн эрсдэлээс хамгаалах зорилгоо малын усан хангамж, уст цэгийг нэмэгдүүлэх, засварлах, малын тэжээлийн өвсний фондтой болгоход дэмжлэг үзүүлэх
 - 5.2.4 Татварын тухай багц хуулинд заасан орон нутгийн татвар, ус, газар ашигласны төлбөрийг зөвхөн сумын төсөвт тухай бүрд төлөх;



- 11
- 5.2.5 Дэд бүтэц нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төрийн бус байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно;
 - 5.2.6 Усны барилга байгууламжийн орчинд хэрэв түүх соёлын дурсгалт зүйлс, орон нутгийн иргэдийн тахин шүтдэг болон нутгийн иргэдийн хувьд соёл зан заншлын ач холбогдол бүхий газруудыг хөндөхгүй байх, хөндөгдөх тохиолдолд тэдгээрийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх;
 - 5.2.7 Малчдын өвөлжөө, хаваржаа түүний орчин тойрон дахь малын бэлчээр, хадлангийн талбай, худаг ундны усны эх үүсвэрт хохирол учруулахгүй байх, хохирол учирвал учирсан хохирлын нөхөн олговрыг олгох буюу түүнтэй адилтгах арга хэмжээг авч ажиллах;
 - 5.2.8 Шаардлагатай тохиолдолд тоосжилтоос хамгаалах зорилгоор усжуулалт хийх замаар тоосжилтыг багасгах арга хэмжээ авах,
 - 5.2.9 Олимп, дэлхийн аварга, олон улсын спортын арга хэмжээнд оролцох Эрдэнэхайрхан сумын харъяат тамирчдад дэмжлэг үзүүлэх.

Зургаа. Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

- 6.1 Компани нь сум орон нутгийн тогтвортой хөгжил, дэд бүтцийг сайжруулах, иргэдээс гарсан санал санаачлагуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой нэг ТББ-тай гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.

Долоо. Баталгаа


- 7.1 Бүрэн эрх. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар Талууд нь энэхүү Гэрээг байгуулах бүрэн эрхтэй гэдгээ үүгээр нотолж байна.
- 7.2 Нууц хадгалах. Талууд гэрээ байгуулснаар мэдэх болсон нөгөө талынхаа бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар нөгөө талдаа хортойгоор ашиглахгүй, гуравдагч этгээдэд задруулахгүй.

Найм. Маргаан шийдвэрлэх

- 8.1 Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана.
- 8.2 Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарах маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшилцөөнд хүрч чадаагүй тохиолдолд маргаанаа шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Бусад

- 9.1 Гэрээний талууд харилцан тохиролцсон тохиолдолд гэрээ, гэрээний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан бүхий л нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Ийнхүү бичгээр үйлдсэн гэрээний нэмэлт өөрчлөлт, хавсралт нь үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг бөгөөд адил хүчин чадалтай байна.
- 9.2 Гал түймэр, цахилгааны болон бусад техник хэрэгслийн саатал, үер, хүчтэй аадар бороо, мөндөр, салхи шуурга, газар хөдлөлт, төр засгийн шийдвэр, онц байдал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гоц халдварт өвчний улмаас тогтоосон хөл хорио гэх мэт Компани өөрөө хянан шийдвэрлэх боломжгүй давтагдашгүй хүчин зүйлс нь Компаний хэвийн үйл ажиллагааг



саатуулж, олборлолтын хэмжээг бууруулж, Компаний санхүүгийн чадавхид нөлөөлж болзошгүй хүчин зүйлс бий болсон тохиолдолд гэрээний үүргийн биелэлтийг уг нөхцөл байдлыг даван туултал хойшлуулж болно.

- 9.3 Гэрээг 2 хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг нэг хувийг хадгалсан нь адил хүчинтэй байна.
- 9.4 Гэрээтэй холбоотой бүхий л мэдэгдэл, зөвлөлгөө, хүсэлтийг Талууд бичгээр дараахь албан ёсны хаягаар илгээнэ.

9.4.1 Хэрэв Сүмд хүргүүлэх бол:

Хаяг: Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум,
Хайрхан баг, Засаг даргын Тамгын газар

Мэдэгдэл хүргүүлэх албан тушаалтан:

ИТХ-ын дарга Н.Батбаяр
Засаг дарга О.Чулуунбаатар

Утас: 88464639

Утас: 88605248

9.4.2 Хэрэв Компанид хүргүүлэх бол:

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Сэнтраул тауэр, 7 давхар,

Баян Айраг Эксплорэйшн ХХК.

Утас: (+796) 77116100

E-mail: enkhtuvshin.yu@bayanairag.com; bill.colvin@bayanairag.com


Мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий албан тушаалтан:

Гүйцэтгэх захирал
Ерөнхий Захирал


Виллиам Томас Колвин
Ю.Энхтүвшин

Гэрээ байгуулсан:

Сумыг төлөөлж:


О.Чулуунбаатар
Эрдэнэхайрхан сумын
Засаг дарга

Компанийг төлөөлж:


Виллиам Томас Колвин
Гүйцэтгэх захирал
Баян Айраг Эксплорэйшн ХХК

12

**ЗАВХАН АЙМГИЙН ДӨРВӨЛЖИН СУМААС БАЯН-АЙРАГ
ЭКСПЛОРЭЙШН ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутгийн захиргаа түүнийг төлөөлөн Засаг дарга албан тушаалтай Н.Батболд (цаашид орон нутгийн захиргаа гэх), нөгөө талаас Баян Айраг Эксплорэйшн ХХК түүнийг төлөөлөн Гүйцэтгэх Захирал албан тушаалтай Виллиам Томас Колвин (цаашид Компани гэх) нар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулав.

НЭГ. Гэрээний үндэслэл

- 1.1 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана" гэсэн заалт нь гэрээний нийтлэг үндэслэл болно.

ХОЁР. Гэрээний хугацаа:

- 2.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. Гэрээний зорилго

- 3.1 Гэрээний зорилго нь Компаниас Завхан аймгийн Дөрвөлжин сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн ам, мал аж ахуй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг стандартад заасан хамгийн бага хэмжээнд байлгах, нөлөөлөлд өртсөн айл өрх, иргэдийн хохирол эрсдлийг барагдуулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх болон компанийн үйл ажиллагааны эдийн засгийн эрхийг хүндэтгэж, тогтвортой, тасралтгүй, хэвийн байдлыг хангаж, орон нутгийн удирдлага, нутгийн иргэд, компанийн хооронд ил тод, шударга, нээлттэй хамтран ажиллах харилцааг бий болгоход тус тус оршино.
- 3.2 Гэрээний талууд гэрээг тайлбарлах, хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, тэгш оролцоотой байх, шударга ёсыг сахих, харилцан ашигтай, ил тод нээлттэй байх, шударгаар сахин биелүүлэх зарчмуудыг хүндэтгэн дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрөв:

ДӨРӨВ. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

- 4.1 Орон нутгийн захиргааны эрх, үүрэг:
- 4.1.1 Байгаль орчныг хамгаалах талаар компанийн үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хяналт тавьж, зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэх буюу хариуцлага хүлээлгүүлэхээр эрх бүхий байгууллага албан тушаалтанд гомдол, шүүхэд нэхэмжлэл гаргах.
- 4.1.2 Энэхүү гэрээний зорилго, мөн чанар, агуулга, ач холбогдлыг орон нутгийн иргэдэд танилцуулан ойлгуулах.

- 4.1.3 Компанийн хууль ёсны үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй явуулах таатай нөхцлийг бүрдүүлэх.
 - 4.1.4 Осол болон бусад шалтгаанаар төслөөс байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал бий болсон тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авч, уурхайн талбайд нэвтрэн орж, хяналт шалгалт хийх. Уурхайн талбайд орохдоо уг талбайд дагаж мөрдөх дүрэм, журам, аюулгүй байдлын зааварчилгатай танилцаж, мөрдөх үүрэгтэй.
 - 4.1.5 Компани холбогдох хууль болон энэ гэрээгээр хүлээсэн байгаль орчны үүрэгтэйгээ холбогдуулан хүргүүлсэн тайлан, мэдээллийг тухай бүр нь хүлээн авч, танилцах, нийтэд мэдээлэх.
 - 4.1.6 Компанийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгах, нөхөн сэргээлт хийхийг компаниас шаардах.
 - 4.1.7 ✓ Компани холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тохиолдолд компани уг үүргээ биелүүлэх хүртэл хууль тогтоомжид заасан үндэслэлээр тухайн компанид төсөлтэй холбоотой зөвшөөрөл (газар, ус ашиглах гэх мэт), тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал өгөхгүй бөгөөд зөрчлөө арилгахгүй байвал энэхүү гэрээ болон төсөлтэй холбоотой олгосон зөвшөөрлүүдэд хуульд заасан журмын дагуу зохих арга хэмжээг авах.
 - 4.1.8 Байгаль орчны чиглэлээр хууль болон энэхүү гэрээгээр хүлээсэн компанийн үүргийн биелэлтэд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэг бүхий сумын иргэдийн оролцоотой төрийн бус байгууллага (ТББ)-д дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
 - 4.1.9 ✓ Компанийн хаягдал ус тогтоох цэгийн байршлыг зааж өгөх.
 - 4.1.10 ✓ Төсөлд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох газрыг заах, үйл ажиллагаа, төлбөр төлөлтөд хяналт тавих.
- 4.2 Компанийн эрх, үүрэг:
- 4.2.1 Ашигт малтмалын тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудад заасан эрх эдэлж, үүрэг хүлээх ба байгаль орчны холбогдолтой Монгол Улсын стандарт, нормыг ханган ажиллах.
 - 4.2.2 Компанийн хэрэгжүүлж буй төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуулбар хувийг Орон нутгийн захиргаанд хүргүүлж чандлан мөрдөх.
 - 4.2.3 Компани Сумын төлөөллийн оролцоотойгоор улирал тутамд уурхай орчмын хөрс, ус, агаараас дээж авах, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх, шинжилгээний дүн, тайланг Орон нутгийн захиргаанд хүргүүлэх.
 - 4.2.4 Хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, мал аж ахуйд учирч болзошгүй хортой нөлөөллийг тодорхойлох, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
 - 4.2.5 ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд уул уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, мал, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусган, хэрэгжүүлэх.
 - 4.2.6 Экологийн боловсрол, хүмүүжил олгох чиглэлээр ТББ, орон нутгийн захиргаанд дэмжлэг үзүүлэх.
 - 4.2.7 Сумын цөлжилттэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх.
 - 4.2.8 Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хяналт, мониторинг хийх, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, төслөөс байгаль орчинд нөлөөлж буй нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл хийх, санал авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах.
 - 4.2.9 Компани орон нутгийн захиргаанд дараах мэдээ, тайланг хүргүүлнэ:

- a. Тус сумаас ашиглаж буй гүний худгийн усны нөөцөд сар бүр мониторинг хийж, мэдээг улирал тутамд ТББ болон орон нутгийн захиргаанд хүргүүлэх;
- b. Тухайн жилд төсөлд ашиглагдах химийн хорт болон аюултай бодис, шатах тослох материалын жагсаалтыг жил бүрийн эхний улиралд бэлтгэн, орон нутгийн захиргаанд хүргүүлэх;
- c. Засгийн газрын холбогдох байгууллага, албан тушаалтанд заавал тайлагнах ёстой байгаль орчинд сөрөг нөлөө бүхий осол, эрсдэл, түүний үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлангийн хувийг орон нутгийн захиргаанд гаргаж өгөх;
- d. Тухайн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар орон нутгийн захиргаанд тайлагнах.

ТАВ: Ажлын байр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авалт хийх талаар

- 5.1 Орон нутгийн захиргааны эрх, үүрэг:
 - 5.1.1 Компаниас зарлагдсан ажлын байрыг сумын иргэдэд нээлттэй мэдээлэх.
 - 5.1.2 Компанитай хамтран сумын нутгийн иргэдийг сургалтад хамруулах замаар ажлын байран дээр дэвших боломжийг бүрдүүлэх.
 - 5.1.3 Компанид нийлүүлэх худалдан авалтад тавигдах шаардлагыг хангуулж, төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх.
 - 5.1.4 Компаниас зарлагдсан ажлын байр дахь сонгон шалгаруулалтад орон нутгаас ажиллах нэр дэвшигчдийн талаар санал өгөх, саналын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүлээн авах.
- 5.2 Компанийн эрх, үүрэг:
 - 5.2.1 Компани хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, стандартад заасан ажлын байрны нөхцлийг хангах үүрэгтэй.
 - 5.2.2 Компанид гарсан сул ажлын байрыг нэн түрүүнд нутгийн иргэдэд санал болгох замаар сумын иргэдийн ажлын байрыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
 - 5.2.3 Тус сумын харьяалалтай компанийн ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, мэргэжилтэй болгоход анхаарал хандуулах.
 - 5.2.4 Шинээр авах ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхойлон, олон нийтэд зарлуулахаар орон нутгийн захиргаанд тухай бүр мэдэгдэх.
 - 5.2.5 Өөрсдийн санаачилгаар жижиг дунд үйлдвэр байгуулан ажиллаж байгаа Дөрвөлжин сумын харьяалалтай иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд дунд компанид хэрэгцээт бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэх төслийг сонгон шалгаруулах, өөрийн эрх мэдлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх, тэдний үйлдвэрлэсэн, стандарт, шаардлагыг бүрэн хангасан бараа, ажил үйлчилгээг худалдан авах замаар ажлын байр нэмэгдүүлэх.
 - 5.2.6 Компанийн олборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон эхэлсний дараа 3 сар тутам хэрэгцээт бараа, ажил үйлчилгээний жагсаалтыг нутгийн захиргаанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэх.
 - 5.2.7 Орон нутгийн иргэдээс ажиллах ажлын байрны 50%-иас доошгүй хувьд Дөрвөлжин сумын харьяат эсвэл уугуул иргэдийг авч ажиллуулахыг зорих.

А

ЗУРГАА: Дэд бүтэц, нийгмийн асуудлын талаар

- 6.1 Орон нутгийн захиргааны эрх, үүрэг
 - 6.1.1 Шаардлагатай тохиолдолд уурхайд эмнэлэг, харилцаа холбоо, цагдаагийн үйлчилгээ үзүүлэх.
 - 6.1.2 Уул уурхай үйл ажиллагаанд шаардлагатай зам, харилцаа холбоо, эрчим хүчний байгууламж барихад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.
- 6.2 Компанийн эрх, үүрэг
 - 6.2.1 Тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших эртний булш, бунхан, түүх соёлын дурсгалт зүйлс, орон нутгийн иргэдийн тахин шүтдэг болон нутгийн иргэдийн хувьд соёл, зан заншлын ач холбогдол бүхий газруудыг хөндөхгүй байхыг зорих, хөндөгдсөн тохиолдолд нүүлгэн шилжүүлэх.
 - 6.2.2 Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд учирсан хохирлыг нөхөн төлөх, тэднийг нүүлгэн шилжүүлж, зохих дэмжлэг үзүүлэх.
 - 6.2.3 Нөлөөнд өртөж байгаа малчдын өвөлжөө хаваржаа, түүний орчин тойрон дахь малын бэлчээр, хадлангийн талбай, худаг, ундны усны эх үүсвэрт хохирол учруулахгүй байхыг зорих, тэдгээрт үзүүлсэн нөлөөллийг эрх бүхий байгууллагаар тогтоолгон тэдэнд учирсан хохирлын нөхөн олговрыг олгох буюу түүнтэй адилтгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
 - 6.2.4 Ган, зуд, халдварт өвчин зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлүүдэд өртсөн тохиолдолд Орон нутгийн захиргаатай хамтран нийгмийн хариуцлагыг ухамсарлах.
 - 6.2.5 Малчдын өвөлжөө, хаваржаа, худгийг нүүлгэн шилжүүлэхэд олгосон нөхөн олговор болон худаг, ус, бэлчээртээ хүрэх замыг хааж боогдуулснаас өөр эх үүсвэр бий болгоход гарсан зардлыг үнэн зөвөөр тайлагнах.
 - 6.2.6 Бэлчээрийн эрсдлээс хамгаалах зорилгоор малын усан хангамж, уст цэгийг нэмэгдүүлэх, засварлах, малын тэжээлийн ургамлыг тариалж өвсний фондтой болгоход дэмжлэг үзүүлэх.
 - 6.2.7 Дэд бүтэц, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төрийн бус байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах, гэрээний биелэлтийн талаарх тайланг нутгийн захиргаа, ИТХ-д хүргүүлэх.
 - 6.2.8 Дэлхийн болон олимпын спортын арга хэмжээнд оролцох Дөрвөлжин сумын харьяат эсвэл уугуул тамирчдыг дэмжихийг зорих.

ДОЛОО. Гэрээний хариуцлага

- 7.1 Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс байгаль орчин, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, эрх ашигт учруулсан хохирлыг холбогдох тал хариуцаж арилгах үүрэгтэй.

НАЙМ. Маргаан шийдвэрлэх

- 8.1 Талуудын дунд гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой ямар нэгэн маргаан, зөрчил гарвал шүүх, хуулийн байгууллагад хандахаас өмнө маргааныг эв зүйгээр шийдвэрлэх боломжтой бүх арга хэмжээг талууд авна.

ЕС. Бусад

- 9.1 Гэрээний талууд харилцан тохиролцсон тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний оруулсан бүхий л нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Ийнхүү бичгээр үйлдсэн гэрээний нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг бөгөөд адил хүчин чадалтай байна.

9.2 Гал түймэр, цахилгааны болон бусад техник хэрэгслийн саатал, үер, хүчтэй аадар бороо, мөндөр, салхи шуурга, газар хөдлөлт, төр засгийн шийдвэр, онц байдал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гоц халдварт өвчний улмаас тогтоосон хөл хорио гэх мэт Компани өөрөө хянан зохицуулах боломжгүй давагдашгүй зүйлс нь Компанийн хэвийн үйл ажиллагааг саатуулж, олборлолтын хэмжээг бууруулж, Компанийн санхүүгийн чадавхид нөлөөлж болзошгүй хүчин зүйлс бий болсон тохиолдолд гэрээний үүргийн биелэлтийг уг нөхцөл байдлыг даван туултал хойшлуулж болно.

9.3 Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд бүгд адил хүчин чадалтай байна. Дараах талууд гэрээний хувийг хадгална:

- Сумын Засаг дарга
- Компани

9.4 Гэрээнд талууд албан ёсоор гарын үсэг зурсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

Орон нутгийн захиргааг төлөөлөн:

Сумын Засаг дарга

Хаяг: Завхан аймаг, Дөрвөлжин сум, Буга баг



/Н. Батболд/

Компанийг төлөөлөн:

Баян Айраг Эксплорэйшн ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

Хаяг: Сэнтрал Тауэр 7 давхар, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот



/Виллиам Томас Колвин/

Батлав.

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын/албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхбаатар



Батлав.

"Баян-Айраг Эксплорейшн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Виллиам Томас Колвин-и



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2015 оны 4 сарын 1-ны өдөр Дугаар 01 Завхан аймаг, Улиастай сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу "Монгол ус" төрийн өмчит үйлдвэрийн газрын 2015 оны 02-р сарын 03-ны өдрийн 29 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 09 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ганболд овогтой Эрдэнэбилэг.

Ус ашиглагчийг төлөөлж: Завхан аймгийн Дөрвөлжин сумын төвөөс зүүн хойш 25 км-т, Цогт багийн нутагт орших, 9019015031 улсын бүртгэл, 2708701 регистрийн дугаартай "Баян-Айраг Эксплорейшн" ХХК-ны т байгаль орчны хэлтэсийн ахлах мэргэжилтэн Мягмаржав овогтой Сарантуяа нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологийн усны хэрэгцээнд;

2.2. Ашиглах усны хэмжээ: нийт 230 464 м³/хоног

2.2.1 Технологийн ус - 188 281,6 м³

2.2.2 Биологийн нөхөн сэргээлтэнд- 10 800 м³/хоног

2.2.3 Уурхайн доторхи зам талбайн усалгаа- 31 382,4 м³/хоног

Баян-Айраг эксплорейшн ХХК-ийн 2015 онд ашиглах усыг доорх өрөмдмөл худгуудаас авч ашиглана.

№	Худгийн нэр	Х	У	Худгийн гүн	Ундарга л/с
1	PB1	65° 79' 56"	53° 01' 66"6	90	15
2	PB2	65° 82' 44"	53° 02' 04"8	124	5
3	PB3	65° 80' 58"	53° 01' 06"3	155	0,49

2.2.4. үйлчилгээ, м³/хоног

2.2.5. эмчилгээ, сувилгаа, хүн/хоног

2.3. Усны чанар, найрлага:

Уурхайн үйлдвэрлэлийн талбайн Их хайрханы хөндийн хяналтын цооногууд, ашиглалтын худгуудын усны чанарын шинжилгээг улирал бүр шинжлүүлж байх

Шинжилгээний дүнг улирал бүр ирүүлэх.

2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил: Уурхайд Их хайрханы хөндийн нийт гүний 3 ш худаг (PB1, PB2, PB3) ашиглана.

Барилга байгууламж: Өрөмдмөл худаг

Тоног төхөөрөмжийн нэр, марк Грунт фос ус өргөгч, SPS 60-14 хөдөлгүүртэй PB1 худаг

Тоног төхөөрөмжийн нэр, марк Грунт фос ус өргөгч, SPS 60-14 хөдөлгүүртэй PB2 худаг

Тоног төхөөрөмжийн нэр, марк Грунт фос ус өргөгч, SPS 60-14 хөдөлгүүртэй PB3 худаг

Хүчин чадал:

PB1 худаг- ундарга 15 л/с

PB2 худаг- ундарга 5 л/с

PB3 худаг- ундарга 0,49 л/с

2.5. Хаягдал усны:

Хэмжээ: Унд ахуйн хэрэгцээнд нормоор тооцоход жилд 21600м^3 ус хэрэглэж, хэрэглээнээс гарах бохир усыг бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэж, ногоон байгууламжийн усалгаанд ашиглуулахаар БОНХЯ-ны БХЗГ-ын дүгнэлтэд заасны дагуу цэвэрлэгээг хийсэн байх

Стандартын шаардлага: Хаягдал усыг “Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага” (MNS 4288-95)-ыг хангасан цэвэрлэх байгууламжид ариутгаж цэвэршүүлсэн байх

Хаягдал ус зайлуулах цэгийн байршилыг Мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Дөрвөлжин сумын Засаг даргын шийдвэрээр тогтоолгоно. Солбицлыг цэг тогтоосон үед нөхөн бичнэ.

Солбилцол: X....., Y....., Z

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис,-50мг/л

Нийт азот,-15мг/л

Аммонни, кг-6мгИ/л

БХХ₅ гр-20мгО/л

Үлдэгдэл хлор.....-1мг/л

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд санал болгосон ахуйн шингэн хаягдлыг шийдвэрлэх бохирын системүүдээс сонгон авч хэрэгжүүлэх, цэвэрлэгээний түвшинг стандартын шаардлагад нийцүүлсэн байх

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

Унд-ахуйн усны эх үүсвэрт ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, журамлах, ус тээвэрлэхэд зориулалтын машин, ус хадгалах ган ашиглах

Тосгон болон үйлдвэрлэлийн ажлын үед гарах ахуйн бохир усыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, бохир усны цэвэршилтийн зэргийг хянах зорилгоор усанд хими, бактериологийн шинжилгээг тогтмол хийж байх

Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, усны бохирдол, усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах /улирал бүр/

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг тухайн оны онцлог байдалд тохируулан нарийвчлан төлөвлөн хэрэгжүүлж байх

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд усны бохирдол, нөлөөллийг бууруулахад зориулж 2015 онд төгрөг тусгасан байна.

2.9. Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар: PB1 худаг 092204 дугаартай

Загвар:MR

Тоолуурын тоо 1

Суурилуулсан байгууллага, огноо Баян-Айраг эксплорэйшн ХХК, 2013 оны 4 сарын 21

Баталгаажуулсан байгууллага, огноо

Тоолуурын заалт: 13727

Төрөл, нэр, дугаар: PB2 худаг 092205 дугаартай

Загвар: MR

Тоолуурын тоо 1

Суурилуулсан байгууллага, огноо Баян-Айраг эксплорэйшн ХХК, 2013 оны 4 сарын 20

Баталгаажуулсан байгууллага, огноо

Тоолуурын заалт :586

Төрөл, нэр, дугаар: PB3 худаг 092206 дугаартай

Загвар: MR

Тоолуурын тоо 1

Суурилуулсан байгууллага, огноо Баян-Айраг эксплорэйшн ХХК, 2013 оны 4 сарын 19

Баталгаажуулсан байгууллага, огноо

Тоолуурын заалт: 9724

Стандартын шаардлага: 3 худгийн тоолуурыг баталгаажуулсан байх.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Технологийн ус хэрэглээ:

$2716 \times 1.8 = 4888.8$ /итгэлцүүр/

$4888.8 \times 1.6 \times 10^3 = 7822080$ т.т.

$7822080 \times 0.2 = 1564416$ т.т.

Зам талбайн усалгаа

$2716 \times 0.25 = 679$ т.т.

$679 \times 31382.4 = 21308649.6$ т.т.

$21308649.6 \times 0.1 = 2130864.96$ т.т.

Биологийн нөхөн сэргээлт

$2716 \times 0.25 = 679$ т.т.

$679 \times 10800 = 7332000$ т.т.

$7332000 \times 0.1 = 733200$ т.т.

Нийт төлбөр 186 958 402,1 ₮

/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

Ус ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх
Жич: Сарын эцэст ус ашигласан 3 худгийн тоолуурын заалтыг баталгаажуулахаар
Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Байгаль орчны улсын байцаагч Р.
Мөнхжаргал, Байгаль хамгаалагч Ж. Тамжид, Баян-Айраг Эксплорейшн компанийн
байгаль орчины хэлтэсийн мэргэжилтэн нар хамтран баталгаажуулах. Улирал тутам
Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа очиж баталгаажуулах.

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

Засгийн газрын тогтоол гарсаны дараа төлбөрийг тооцно.
/ус бохирдуулсны төлбөр/

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4,
19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс
эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт,
хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр
үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.


4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх
бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

.....


/Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ганболд овогтой Эрдэнэбилэг /

Ус ашиглагчийг төлөөлж:

.....


/"Баян-Айраг Эксплорейшн" ХХК-тусгай зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Мягмаржав овогтой Сарантуяа /

Харилцах утас: 99469187,96469187

Харилцах утас:88104450